

БАТЛАВ.
ЭРЧИМ ХҮЧНИЙ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.БАТ-ЭРДЭНЭ



БАТЛАВ.
“ДЦС-3” ТӨХК-ийн ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Л.ЭРХБААТАР



“ИНЖЕНЕРИЙН ЧАДВАР-ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ,
ОНОЛ ПРАКТИКИЙН XV БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

2024 оны 04-р сарын 18

Улаанбаатар хот

НЭГ. ЗОРИЛГО

“ДЦС-3” ТӨХК болон Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Эрчим хүчний сургууль уламжлал болгон хамтран зохион байгуулдаг эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлыг энэ жил Эрчим хүчний сургуулийн Дулааны инженерийн салбар үүсч хөгжсөний 60 жилийн ойд зориулж байгаа бөгөөд энэхүү хурлын зорилго нь үйлдвэр, сургалтын байгууллагын холбоог өргөжүүлэх, ажилтнуудын илтгэл эрдэм шинжилгээний өгүүлэл бичих чадварыг дээшлүүлж, судалгааны ажлын арга барилд суралцуулах, байгууллагын бүтээмжийг дээшлүүлэхэд оршино.

ХОЁР. ХУРЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

“ДЦС-3” ТӨХК-ийн ИТА, ажилтнууд болон их дээд сургуулиудын эрдэмтэн, багш, судлаач оюутнууд хамтарч оролцоно.

ГУРАВ. ХУГАЦАА, ГАЗАР

2024 оны 05-р сарын 17-ны өдрийн 09.00-17.00 цагт “ДЦС-3” ТӨХК-ийн хурлын танхимд болно.

ДӨРӨВ. ИЛТГЭЛИЙН СЭДВИЙН АГУУЛГА

Хоёр жил тутамд зохион байгуулагддаг энэхүү хамтарсан эрдэм шинжилгээ, онол практикийн бага хуралд тавигдах илтгэлүүд нь Эрчим хүчний салбарт төрөөс баримтлаж буй бодлого, хөгжлийн хандлагад нийцсэн нэвтрүүлж буй болон нэвтрүүлэх боломжтой байгаль орчинд ээлтэй шинэ дэвшилтэт, ногоон техник технологи, тэдгээрийн техникийн болоод эдийн засгийн үр ашгийн тухай, техник тоног төхөөрөмжийн насжилт, ашиглалтын түвшин, засварын технологи, чанарыг сайжруулах, бүтээмжийг дээшлүүлэх, эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна. Илтгэлүүд дараах 4 үндсэн чиглэлд хуваагдана. ҮҮНД:

- 1) Шинэ дэвшилтэт техник, технологи
- 2) Ухаалаг техник, технологийн шийдлүүд
- 3) Эрчим хүчний хэмнэлт, үр ашиг
- 4) Менежментийн стандартуудын хэрэгжилт

ТАВ. ИЛТГЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Илтгэл нь урьд өмнөх Эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлуудад хэлэлцүүлэгдэж байгаагүй, сүүлийн 2 жилд “ДЦС-3” ТӨХК-д хэрэгжсэн туршлага болон тус компанид хэрэгжүүлэхээр санал болгож буй шийдлүүд байна.

Агуулгын хүрээнд тоо баримт статистик үзүүлэлт ашигласан, үзэл санаагаа товч тодорхой илэрхийлж шинэ шийдэл тусгасан, эдийн засгийн үр ашгийг судалгааны аргачлал, арга ашиглан тооцсон байна.

ШУТИС Эрчим хүчний сургуулийн болон бусад их дээд сургуулийн багш нартай хамтарсан байна. Илтгэлийн хамтарсан зохиогчоор шүүгчдийн бүрэлдэхүүний гишүүд оролцохгүй.

Илтгэл / эрдэм шинжилгээний өгүүлэл/-д тавигдах шаардлага:

1. Microsoft office word программ ашиглан А4-н цаасан дээр захын зайг зүүн талаас 30, баруун талаас 15, дээд болон доод талаас 20 мм байхаар тохируулна.
2. Times New Roman фонд сонгон илтгэлийн нэрийг 12 pt, зохиогчийн нэр болон текстийг 10 pt байхаар бичнэ.
3. Илтгэлд оруулсан зураг, графикийг jpg файлаар илтгэлтэй хавсаргаж явуулна.
4. Хуудас дугаартай, өгөгдсөн эрдэм шинжилгээний өгүүллэгийн загварын дагуу 2 эгнээгээр 6-аас ихгүй хуудас байх

Илтгэлийг Хавсралт-1 -аар өгөгдсөн жишээний дагуу IEEE стандартын өгүүлэл бичих загварын дагуу бичнэ.

ЗУРГАА. ИЛТГЭЛИЙГ ШАЛГАРУУЛАХ ҮЗҮҮЛЭЛТ

Илтгэлийг шалгаруулахдаа илтгэлд тавигдах ерөнхий шаардлагаас гадна дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ. Үүнд:

1. Судалгаа шинжилгээний арга зүй
2. Ашиглаж судалсан материал, эх сурвалжийн байдал
3. Дүгнэлт, санал нь бодитой, үр ашигтай, хэрэгжих боломжтой эсэх
4. Асуудал дэвшүүлж зорилгодоо хүрсэн байдал
5. Илтгэлийн ерөнхий шаардлага хангасан байдал

Үзүүлэлт бүрийг 20 оноогоор дүгнэх бөгөөд нэг илтгэлд 100 хүртэлх оноо өгөгдөнө.

ДОЛОО. УРАЛДААНД ИРҮҮЛЭХ ИЛТГЭЛИЙГ БҮРТГЭХ БА ШАЛГАРУУЛАХ

7.1 Бүртгэл, илтгэл хүлээн авах

Ирүүлэх илтгэлийн нэр, зохиогч нарын товч танилцуулгыг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны дотор илгээн бүртгүүлнэ. Илтгэлийн хүлээн авах хугацаа 2024 оны 05 дугаар сарын 13-ий өдрийн 17 цагаар хаалт хийгдэнэ. Бүртгэлийн танилцуулга болон илтгэлийг amgalantuyab@gmail.com хаягаар хүлээн авна.

7.2 Шалгаруулалт

Ирүүлсэн илтгэлүүдийг шүүгчдийн бүрэлдэхүүн дүгнэн, нийлбэр оноогоор гарган, эхний дарааллаар 10 илтгэлийг шалгаруулна. Эхний 10 илтгэлийг хурал болох өдрөөс 1 өдрийн өмнө зохиогч нарт мэдэгдэх тул илтгэлийн файлаа ирүүлэхдээ оролцогч нар 15 минутын танилцуулгыг (ppt) мөн боловсруулан, бэлтгэлээ хангасан байна.

Эрдэм шинжилгээ, онол практикийн бага хуралд хэлэлцүүлэх илтгэлийн танилцуулга 15 минутаас хэтрэхгүй. Асуулт хариулт 5 минут байна.

Хуралд хэлэлцүүлэгдсэн илтгэлүүдийг дүгнэн, нийлбэр онооны дарааллаар шалгаруулж урамшуулна.

НАЙМ. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

I байр. Нэг бүтээл – Өргөмжлөл, 700 000 төгрөг.

II байр. Нэг бүтээл – Өргөмжлөл 500 000 төгрөг

III байр. Нэг бүтээл – Өргөмжлөл, 400 000 мянган төгрөг

Тусгай байр. Хоёр бүтээл–тус бүр Өргөмжлөл, 200 000 төгрөг

Ерөнхий шаардлагыг ханган, эмхэтгэлд бүтээл нь орсон оролцогч бүрд – Батламж

ЕС. ШҮҮГЧИД

Шүүгчийн бүрэлдэхүүнд :

Дарга : “ДЦС-3” ТӨХК – ийн Ерөнхий инженер Н.Чимэддорж

Гишүүд :

ЭХС-ийн ДИС-ын эрхлэгч, доктор (Ph.D) Б.Баттөр

ЭХС-ийн ЦИС-ын эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор Ш.Гантөмөр

Шинэ СЭХС-ын эрхлэгч, доктор (Ph.D) М.Ганхүлэг

“ДЦС-3” ТӨХК-ийн ҮА-ны дарга Л.Бөхболд

“ДЦС-3” ТӨХК-ийн ЗХА-ны дарга Ц.Батмагнай

“ДЦС-3” ТӨХК-ийн ТБХ- ийн дарга Г.Амартүвшин

10. ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Дарга : “ДЦС-3” ТӨХК-ийн ТБХ- ийн дарга

Г.Амартүвшин

Нарийн бичгийн дарга : ЗХНА-ны Сургалтын инженер

Д.Баярмагнай

Гишүүд: ЭХС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D)

Д.Үлэмж

ЭХС-ийн ДИС-ын эрхлэгч, доктор (Ph.D)

Б.Баттөр

ЭХС-ийн ДИС-ын ахлах багш, доктор (Ph.D)

А.Түмэнбаяр

ҮААХ-н дарга

Ц.Батхуяг

ЗХНА-ны сургалтын инженер

П.Болормаа

ТБХ-ийн төслийн инженер, доктор (Ph.D)

Б. Амгалантуяа

ДХХА цехийн техник хангамжийн инженер

Б.Сүхбаатар

Модератор :

ЭХС-ийн ДИС-ын ахлах багш, доктор (Ph.D) А.Түмэнбаяр

“ДЦС-3” ТӨХК-ийн ДХХ-ийн ахлах инженер Н.Бямбадорж

ХЯНАСАН:

“ДЦС-3” ТӨХК-ийн ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Н.ЧИМЭДДОРЖ

ТЭЗХ-н ДАРГА

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ТБХ-н ДАРГА

Г.АМАРТҮВШИН

ЭХС-ИЙН ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,

ДОКТОР (Ph.D)

Д.ҮЛЭМЖ

БОЛОВСРУУЛСАН:

ЭХС-ИЙН ДИС-ЫН АХЛАХ БАГШ, ДОКТОР (Ph.D)

А.ТҮМЭНБАЯР

“ДЦС-3” ТӨХК-ийн ЗХНА-ны СУРГАЛТЫН ИНЖЕР

Д.БАЯРМАГНАЙ